



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Аудитын код: ОРА-2022 /4/НА-СТА-БСД

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитор: Б.Азжаргал
Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1.Санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	Error! Bookmark not defined.
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа	13
4.4 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.03.25 № 99

танай _____ -ны № _____ -г

“МӨНХИЙН ГЭГЭЭ” ӨРХИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Г.МЯДАГХАНД ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. “Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант онд 77,283.2 мянган төгрөгийн авлага, 1,217.4 мянган төгрөгийн өр төлбөртэй ажилласан байна.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc



Нийт авлагын 98.2 хувь буюу 75,954.7 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага байна.

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн байна. Шалгалтаар нийт 34,312.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 4,549.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт, 28,500.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 1,263.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл аудитлагдаагүй	Эцсийн үлдэгдэл аудитлагдсан
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	107,799,976.57	107,799,976.57
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,733,656.66	10,733,656.66
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,733,656.66	10,733,656.66
31213	Арилжааны банк дахь харилцах	10,733,656.66	10,733,656.66
33	АВЛАГА	77,283,230.41	77,283,230.41
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,328,530.41	1,328,530.41
33300	Татаас, санхүүжилтийн авлага	75,954,700.00	75,954,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19,783,089.50	19,783,089.50
351	Түүхий эд материал	17,183,529.50	17,183,529.50
35110	Тусгай зориулалттай материал	6,996,036.00	6,996,036.00
35130	Эм боох материал	10,187,493.50	10,187,493.50
354	Хангамжийн материал	2,599,560.00	2,599,560.00
35410	Бичиг хэргийн материал	329,500.00	329,500.00
35420	Аж ахуйн материал	2,127,200.00	2,127,200.00
35440	Түлш, шатах тослох материал	142,860.00	142,860.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	216,995,683.80	216,995,683.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	216,995,683.80	216,995,683.80
392	Биет хөрөнгө	216,670,683.80	216,670,683.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(25,473,166.55)	(25,473,166.55)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,884,000.00	58,884,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(69,860,866.48)	(69,860,866.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	211,342,806.40	211,342,806.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,016,519.33)	(9,016,519.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,021,550.00	32,021,550.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,552,317.00	20,552,317.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,779,437.24)	(1,779,437.24)
393	Биет бус хөрөнгө	325,000.00	325,000.00
39301	Програм хангамж	325,000.00	325,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	324,795,660.37	324,795,660.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,217,363.65	1,217,363.65
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,217,363.65	1,217,363.65
413	Өглөг	1,217,363.65	1,217,363.65
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,217,363.65	1,217,363.65
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	323,578,296.72	323,578,296.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	28,052,305.00	28,052,305.00
	Дахин үнэлгээний нөөц	869,500.00	869,500.00
512	Хуримтлагдсан үр дүн	294,656,491.72	294,656,491.72
51210	Өмнөх үеийн үр дүн	96,296,797.12	96,296,797.12
51220	Тайлант үеийн үр дүн	198,359,694.60	198,359,694.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	324,795,660.37	324,795,660.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	АУДИТЛАГДААГҮЙ	АУДИТЛАГДСАН
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,081,095,010.56	1,081,095,010.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	484,135,053.56	484,135,053.56
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,710,000.00	13,710,000.00
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	470,425,053.56	470,425,053.56
122	Тусламжийн орлого	60,783,000.00	60,783,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	60,783,000.00	60,783,000.00
1330	Төсвийн захирагчдаас	245,395,967.00	245,395,967.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	245,395,967.00	245,395,967.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	290,780,990.00	290,780,990.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	290,780,990.00	290,780,990.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	463,141,238.38	463,141,238.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,141,238.38	463,141,238.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,524,712.48	223,524,712.48
210101	Үндсэн цалин	223,524,712.48	223,524,712.48
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,995,890.70	24,995,890.70
210201	Тэтгэврийн даатгал	19,673,028.59	19,673,028.59
210202	Тэтгэмжийн даатгал	915,605.48	915,605.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	32,347.20	32,347.20
210204	Ажилгүйдлийн даатгал	191,548.73	191,548.73
210205	Эрүүл мэндийн даатгал	4,183,360.70	4,183,360.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,172,127.72	7,172,127.72
210301	Гэрэл, цахилгаан	2,570,847.72	2,570,847.72
210302	Түлш, халаалт	2,355,000.00	2,355,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,246,280.00	2,246,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,981,231.00	14,981,231.00
210401	Бичиг хэрэг	4,756,800.00	4,756,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,565,240.00	3,565,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	639,400.00	639,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	700,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,319,791.00	5,319,791.00
2105	Нормативт зардал	144,031,092.00	144,031,092.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	135,432,584.00	135,432,584.00
210502	Хоол, хүнс	7,668,508.00	7,668,508.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	930,000.00	930,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,146,800.00	1,146,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	136,000.00	136,000.00
210604	Урсгал засвар	1,010,800.00	1,010,800.00
2107	Томиллолт, зочны зардал	522,660.00	522,660.00
210702	Дотоод албан томиллолт	114,000.00	114,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	408,660.00	408,660.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,163,317.00	4,163,317.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,588,317.00	3,588,317.00



“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	109,660.00	109,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	81,400.00	81,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	83,940.00	83,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,721,698.48	30,721,698.48
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,435.00	1,300,435.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,421,263.48	29,421,263.48
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,881,709.00	11,881,709.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	212,374.00	212,374.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,751,335.00	8,751,335.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,918,000.00	2,918,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	617,953,772.18	617,953,772.18
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	419,594,077.58	419,594,077.58
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,750,000.00	2,750,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	416,844,077.58	416,844,077.58
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(419,594,077.58)	(419,594,077.58)
5	НИЙТ ҮР ДҮН	198,359,694.60	198,359,694.60

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТЛАГДЛАГДСАН					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	96,296,797.12	125,218,602.12
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	96,296,797.12	125,218,602.12
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	96,296,797.12	125,218,602.12
D08	Тайлант үеийн үр дүн			198,359,694.60	198,359,694.60
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	28,052,305.00	869,500.00	294,656,491.72	323,578,296.72

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	АУДИТЛАГДААГҮЙ	АУДИТЛАГДСАН
		Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	480,465,086.00	480,465,086.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,710,000.00	13,710,000.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13,710,000.00	13,710,000.00
1330	Төсвийн захирагчдаас	245,395,967.00	245,395,967.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	245,395,967.00	245,395,967.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	221,359,119.00	221,359,119.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,532,829.00	6,532,829.00



“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	214,826,290.00	214,826,290.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	414,686,278.18	414,686,278.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	414,686,278.18	414,686,278.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,739,257.76	195,739,257.76
210101	Үндсэн цалин	195,739,257.76	195,739,257.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,957,779.70	36,957,779.70
210201	Тэтгэврийн даатгал	34,403,576.78	34,403,576.78
210202	Тэтгэмжийн даатгал	351,024.00	351,024.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,203,178.92	2,203,178.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,172,127.72	7,172,127.72
210301	Гэрэл, цахилгаан	2,570,847.72	2,570,847.72
210302	Түлш, халаалт	2,355,000.00	2,355,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,246,280.00	2,246,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,580,966.00	20,580,966.00
210401	Бичиг хэрэг	6,798,331.00	6,798,331.00
210402	Тээвэр, шатахуун	3,458,100.00	3,458,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	639,400.00	639,400.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	760,000.00	760,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,875,135.00	8,875,135.00
2105	Нормативт зардал	113,283,232.00	113,283,232.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	104,797,535.00	104,797,535.00
210502	Хоол, хүнс	7,555,697.00	7,555,697.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	930,000.00	930,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,652,950.00	16,652,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	660,750.00	660,750.00
210602	Тавилга	14,582,400.00	14,582,400.00
210604	Урсгал засвар	1,409,800.00	1,409,800.00
2107	Томилолт, зочны зардал	522,660.00	522,660.00
210702	Дотоод албан томилолт	114,000.00	114,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	408,660.00	408,660.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,825,600.00	3,825,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,248,600.00	3,248,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,660.00	111,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	81,400.00	81,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	83,940.00	83,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,800,435.00	1,800,435.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,300,435.00	1,300,435.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,151,270.00	18,151,270.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,481,935.00	6,481,935.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,721,335.00	2,721,335.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,948,000.00	8,948,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	65,778,807.82	65,778,807.82
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	55,108,300.00	55,108,300.00



“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

222001	Тоног төхөөрөмж	12,768,000.00	12,768,000.00
223001	Бусад хөрөнгө	42,340,300.00	42,340,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(55,108,300.00)	(55,108,300.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	10,670,507.82	10,670,507.82
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	63,148.84	63,148.84
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,733,656.66	10,733,656.66

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	282,400,432.00	469,794,578.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	267,150,432.00	414,686,278.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,750,432.00	396,535,008.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,368,832.00	195,739,257.76
210101	Үндсэн цалин	131,100,000.00	195,739,257.76
210102	Нэмэгдэл	43,268,832.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,428,600.00	36,957,779.70
210201	Тэтгэврийн даатгал	3,377,760.00	34,403,576.78
210202	Тэтгэмжийн даатгал	21,788,640.00	351,024.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	262,200.00	2,203,178.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,120,000.00	7,172,127.72
210301	Гэрэл, цахилгаан	2,580,000.00	2,570,847.72
210302	Түлш, халаалт	2,150,000.00	2,355,000.00
210303	Цэвэр, бохир ус	390,000.00	2,246,280.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,440,000.00	20,580,966.00
210401	Бичиг хэрэг	6,000,000.00	6,798,331.00
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	3,458,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	720,000.00	639,400.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	50,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	760,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,600,000.00	8,875,135.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	600,000.00	
2105	Нормативт зардал	25,200,000.00	113,283,232.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,500,000.00	104,797,535.00
210502	Хоол, хүнс	7,200,000.00	7,555,697.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	930,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,605,000.00	16,652,950.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00	660,750.00
210602	Тавилга	8,575,000.00	14,582,400.00
210604	Урсгал засвар	780,000.00	1,409,800.00
2107	Томилолт, зочны зардал	850,000.00	522,660.00
210702	Дотоод албан томилолт	450,000.00	114,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	400,000.00	408,660.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,658,000.00	3,825,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	3,248,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	100,000.00	111,660.00



“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210804	Тээврийн хэрэгслийн татвар	88,000.00	81,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	83,940.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,080,000.00	1,800,435.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	780,000.00	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	1,300,435.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,400,000.00	18,151,270.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,400,000.00	18,151,270.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		6,481,935.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,200,000.00	2,721,335.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,200,000.00	8,948,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,250,000.00	55,108,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,250,000.00	55,108,300.00
222001	Тоног төхөөрөмж	9,500,000.00	12,768,000.00
223001	Бусад хөрөнгө	5,750,000.00	42,340,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	283,927,440.00	480,465,086.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	241,291,440.00	245,395,967.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	241,291,440.00	245,395,967.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,636,000.00	221,359,119.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		6,532,829.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42,636,000.00	214,826,290.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	13,710,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		13,710,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		63,148.84
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		10,733,656.66

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азжаргал гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.



3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн анхан шатны цогц тусламжийг MNS:5292:2017 стандартыг бүрэн хангаж үзүүлэх зорилго бүхий, төрийг үйчилгээг гэрээний үндсэн дээр иргэдэд хүргэх, төсвөөс санхүүждэг, нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 469,794.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,697.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг өөрчлөөгүй бөгөөд 70 хувиар буюу 3,288.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

3.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төв нь санхүүгийн CTS программыг ашигладаг бөгөөд тус программд нэвтрэх 1 эрхтэй ажилтантай буюу ерөнхий нягтлан бодогч өдөр тутмын ажил гүйлгээг оруулж байна.

Харин тус программд үндсэн хөрөнгийг дэлгэрэнгүй оруулахдаа эд хариуцагч бүрийн нэрийг хөрөнгө бүрийн ард тусгаж өгсөн нь хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авсан байна.

3.6 Санхүүгийн тайлангийн тодруулга

“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 198,480.9 мянган төгрөгөөр буюу 38.89 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	63.1	10,733.6	10,670.5
Бараа материал	9,864.7	19,783.1	9,918.4
Үндсэн хөрөнгө	115,943.3	216,995.7	101,052.4
Авлага	443.6	77,283.2	76,839.6
Нийт хөрөнгө	126,314.7	324,795.6	198,480.9
Өр төлбөр	1,096.0	1,217.3	121.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	125,218.6	323,578.3	198,359.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	126,314.7	324,795.6	198,480.9

Бараа материалын данс 9,918.4 мянган төгрөгөөр өссөн нь Covid-19 халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулан бэлэн байдлын нөөц бүрдүүлэлтэнд нэг удаагийн комбинзон, халад, маск, нүүрний хаалт, бээлий мөн ариутгалын бодис болох санитол, спирт, жавлин зэргийг худалдан авсанаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 216,995.7 мянган төгрөг болж 101,052.4 мянган төгрөгөөр өссөн нь өрхийн эмнэлэгийн үйл ажиллагааг хэвийн явуулахад орон нутаг, улсын төсөв, хандив болон өөрийн хөрөнгөөр эмнэлгийн тоног төхөөрөмж болон тавилга, тээврийн хэрэгсэл худалдан авсан нь шалтгаалсан байна.

Касс дахь бэлэн мөнгөний энхний үлдэгдэл 13,500.0 мянган төгрөг байсныг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд эцсийн үлдэгдэл 00 төгрөг харин харилцах дансанд оны эхний үлдэгдэл 63.1 мянган төгрөг, Улсын төсөв болон Эрүүл мэндийн даатгалын сангаас 474,165.1 мянган төгрөгийн санхүүжилт орж үйл ажиллагаандаа 463,494.6 мянган төгрөгийг зарцуулан ба эцсийн үлдэгдэл 10,733.6 мянган төгрөг байна.

2021 оны санхүүгийн тайлангаар нийт 77,283.2 мянган төгрөгийн авлагатай ажилласан байна. Нийт авлагын 98.2 хувь буюу 75,954.7 мянган төгрөгийн авлага нь Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,328.5 мянган төгрөгийн авлага нь ажилчидтай холбоотой авлага байна.

3.7 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төв нь Шанд багийн 768 өрхийн 2783 хүн ам, Даваат багийн 1482 өрхийн 4969 хүн ам, Рашаант багийн 384 өрхийн 1369 хүн ам нийт 9121 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлдэг бөгөөд нэг хүнд ноогдох зардлаар тооцон 2021 оны төсвийн төслөө 245,396.0 мянган төгрөгөөр



төлөвлөж төсвийн ерөнхийлөн захирагчдаа хүргүүлсэнээс 245,396.0 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл

“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төв нь тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр тусгай зориулалтын шилжүүлгээр 245,396.0 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 214,826.3 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 13,710.0 мянган төгрөг, НД-ын сангаас 6,532.8 мянган төгрөг нийт 480,465.1 мянган төгрөгийн санхүүжилт авсанаас 469,794.6 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7.3 Нэмэлт төсөв

3.8 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.9 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төв нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст улирал бүр мэдээллийг ил тод байршуулахаас 2, 3 улирлын мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим



төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, хөтлөвөл зохих санхүүгийн баримтуудыг хөтлөдөггүй, өглөг, авлагатай ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар" хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

“Мөнхийн гэгээ” өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн байна.

Шалгалтаар нийт 34,312.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 4,549.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт, 28,500.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага, 1,263.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 29,915.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнээс 19,298.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж, 176.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, 10,441.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн нь бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	4	19,298.2	4	19,298.2			
Төлбөрийн акт	1	176.2	1	176.2			
Албан шаардлага	1	10,441.0	1	10,441.0			
Нийт дүн	6	29,915.4	6	29,915.4			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,611.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 6,532.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,078.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Зардлын зүйл ангийг буруу сонгосоноор санхүүгийн үр дүнгийн тайланд 6,532.8 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлсэнийг залруулав.



4.2 Төлбөрийн акт Байхгүй.

4.3 Албан шаардлага Байхгүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Зарлагын гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй дутуу баримтаар гүйлгээ хийсэн, Шатах тослох материал зарлагадахдаа НХМаягт БМ-6 маягт, НХМаягт Т-4 маягтуудыг хөтөлдөггүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах. Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

1.3. Илрүүлэлт:

Тайлант онд ажилчидтай холбоотой 1,328.5 мянган төгрөг, ЭМДСангаас 75,954.7 мянган төгрөг нийт 77,283.2 мянган төгрөгийн авлага, ХАОАТ-т 1,217.4 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэн ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.4. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, авлага, өр төлбөргүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	“Мөнхийн гэгээ” Өрхийн эрүүл мэндийн төв	3	9,611.7	1	6,532.8	0	0	0	0	2	3,078.9